



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

“Ээрмэл” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ээрмэл” ХК-ийн оноосон нэрийг “Ариг гал” ХК болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Ариг гал” ХК /Х.Хания/-д үүрэг болгосугай:

1/ Энэхүү тогтоолын 1-д заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, энэ тухай Хороонд мэдэгдэх;

2/ Оноосон нэрийн өөрчлөлтийг ажлын хоёр хоногт багтаан хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутам хэвлэгдэн гардаг сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус бүр хоёроос доошгүй удаа нийтэд мэдээлж, баримтыг Хороонд ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын 1-д заасан оноосон нэр өөрчлөгдсөн талаарх мэдээллийг Монголбанк, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, брокерын компаниуд болон арилжааны банкуудад хүргэж ажиллахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000200